

САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ГАЗРЫН САНХҮҮ, ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН АХЛАХ НЯГТЛАН БОДОГЧ
Р.СОДНОМЦЭРЭНГИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

Ыд/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Үр дүнгийн үзүүлэлт			
		Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Үнэлгээ /хувиар/
1	2	3	4	5	6
НЭГ. “ЯАМНЫ АППАРАТЫН САНХҮҮГИЙН ХЭВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХАНГАХ ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД					
1	Урсгал санхүүжилтийн дансны сарын мэдээ, төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргах	Сар бүрийн мэдээ, төсвийн гүйцэтгэлийн мэдээ /12 удаа/	2024 оны Эхний 11 сарын мэдээ, төсвийн гүйцэтгэлийн тайланг гаргаж, төрийн сангаар хянагдсан байна	Урсгал санхүүжилтын данс болох 100900020001 тоот дансны 2023 оны 12 сар болон 2024 оны 1-11 сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээг Төсвийн тухай хуульд заасан хугацаанд хугацаа хоцроолгүй гарган Төрийн сангаар хянуулж, холбогдох газарт хүргүүлэн ажилласан.	95
2.	Нэмэлт санхүүжилтийн дансны сарын мэдээ, төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргах	Сар бүрийн мэдээ, төсвийн гүйцэтгэлийн мэдээ /12 удаа/	2024 оны Эхний 11 сарын мэдээ, төсвийн гүйцэтгэлийн тайланг гаргаж, төрийн сангаар хянагдсан байна.	Нэмэлт санхүүжилтын данс болох 100900020414 тоот дансны 2023 оны 12 сар болон 2024 оны 1-11 сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээг Төсвийн тухай хуульд заасан хугацаанд хугацаа хоцроолгүй гарган Төрийн сангаар хянуулж, холбогдох газарт хүргүүлэн ажилласан.	95
3.	Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах, тайлагнах , мэдээлэх	Хуулийн хугацаанд байршуулсан мэдээллийн тоо	Ажил үүргийн хуваарийн дагуу шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд оруулах, үнэн зөв бодитой мэдээлэх, санхүүгийн ил тод байдлыг хангаж ажилласан байна.	Шилэн дансны тухай хуулийн дагуу сар бүрийн 08 болон бусад заасан хугацааны дотор Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт- эдийн засгийн ангилал	95

189

			• Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл – Хөтөлбөр, зориулалт • Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл • Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт • Хагас жилийн Санхүүгийн тайлан • Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайлан • Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө • Худалдан авах ажиллагааны тайлан • Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, концессын зүйлийн жагсаалт • Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан	
			• Санхүүгийн тайлан • Байгууллагын батлагдсан төсөв • Дараа жилийн төсвийн төсөл • Хандив, тусламжийн зарцуулалтын тайлан • Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайлан • Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт • Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл	

				• Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл • Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ • Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ • Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт Мэдээллийг хуулийн хугацаанд гарган шилэн дансны shilendans.gov.mn цахим хуудсанд 152 мэдээлэл байршуулсан. Хугацаа хоцроож болон хуулийн хугацаанд байршуулаагүй мэдээлэл байхгүй болно. Мөн аудитын албан шаардлагын дагуу 2023 онд шилэн дансанд байршуулаагүй байсан 15 мэдээллийг нөхөн байршуулсан.	
4	2025 оны Төсвийн төсөл боловсруулан Эрүүл мэндийн сайдын багцын нэгтгэл төсөвт тусгуулах, төсвийн сар улиралын хуваарийн санал боловсруулах	Боловсруулсан төсвийн төсөл, сарын хуваарийн өөрчилөлт	Төсвийн төслийн санал боловсруулсан байна. Тайлант хугацаанд төлөвлөгдсөн болон төлөвлөгөөнд тусгагдаагүй үүссэн зардлын өөрчлөлт, хуваарилалтын санал боловсруулсан байна.	Эрүүл мэндийн яамны 2025 оны төсвийн төлөвлөгөөний төсөл, 2026-2027 оны төсөөллөө Төсвийн тухай хуулийн 8.4.2-дахь зүйлд заасны дагуу 7 дугаар сарын 20-ны өдрийн дотор хүргүүлж 2025 оны төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн саналд нэгтгүүлсэн. Тайлант хугацаанд Бараа үйлчилгээний зардал, Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардал, Гэрээт ажилчидын цалингийн зардал, Гадаад, дотоод томилолтын зардал, Ажил олоогчдоос олгох нэг удаагийн тэтгэмж, шагнал, урамшууллын зардал, Цахим бодлогын арга хэмжээний зардлын хувиарын өөрчилөлтийн саналыг боловсруулж төсвийн холбогдох мэргэжилтнээр хянуулан сар бүрийн төсөвт тусгуулан ажилласан.	95

5	Авлага өглөгийн бүртгэлийг хөтөлж, баримт бүрдүүлбэрт хяналт тавин ажиллах, холбогдох байгууллагуудтай үлдэгдэл баталгаажуулж тооцоо нийлсэн акт үйлдэх	Мөнгөн урьдчилгааны тайлан, Тооцоо нийлсэн акт	Авлага өглөгийн бүртгэлийг хөтлөх, авлага өглөгийг бууруулах	Байгууллагын данс бүртгэлийг хөтлөхдөө Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу тэтгэмж тусламжаас бусад гүйлгээг авлага, өглөгөөр дамжуулан бүртгэж, авлага өглөгийг хаахдаа мөнгөн урьдчилгааны тайлан, тооцоо нийлсэн акт, томилолтын хуудас тайлан, зардлын тооцоо бусад баримт бичгийг үндэслэн барагдуулж ажилласан. Тайлант хугацаанд буюу 12 дугаар 01-ний өдрийн байдлаар холбогдох бичиг баримтыг үндэслэн 4840.5 сая төгрөгийн авлага, 6516.7 сая төгрөгийн өглөгийг бууруулж ажилласан байна. Аудитаас өгөгдсөн албан шаардлагын дагуу 2022 онд Авлагаар андуурч бүртгэсэн 414,262,788 төгрөгийг залруулж /2022 оны 07 сард ХСҮТөвөөс вакцины төлбөр болох 414,262,788 төгрөгийг тус яаманд шилжүүлсэн бөгөөд тус мөнгийг 2022/07/28-нд УТ-с хариуцах эмнэлгийн тусламж үйлчилгээний санхүүжилт 100900020091 тоот дансанд шилжүүлсэн/, Хүннү эйр ХХК-тай авлагын 17,735,346.84 төгрөгийн тооцоог нийлж актаар нөхөн баталгаажуулсан. Мөн аудитаас өгөгдсөн зөвлөмжийн дагуу-2022 оноос өмнө үүссэн Багцын гүйлгээ нэрээр үүссэн эзэн холбогдогч нар нь тодорхойгүй /Вакцины урамшуулал/ 39,550.0 мянган төгрөгийн өглөгийг хааж, Эрүүл мэндийн яам нэрээр үүссэн 922.6 мянган төгрөгийн алдаатай өглөгийн гүйлгээг залруулсан болно.	
6	Мөнгөн хөрөнгийн өдөр тутмын орлого, зарлагын гүйлгээг хянаж, баталгаажуулах	Байгууллагын санхүү бүртгэл болон аж ахуйн хэвийн үйл ажиллагааг ханган ажилласан байх.	Батлагдсан төсвийн хувиарын дагуу санхүүжилтын эрхийг нээлгэх, Мөнгөн хөрөнгөтэй холбоотой өдөр тутмын гүйлгээг хийх,	Батлагдсан төсвийн хувиарын дагуу санхүүжилтын эрхийг нээлгэж, мөнгөн хөрөнгийн өдөр тутмын орлого зарлагын гүйлгээг боловсруулж мөнгөн гүйлгээний үйл ажиллагааг тасалдалгүй явуулсан. Үүнд 12 дугаар сарын 10-ны байдлаар 9,044,339,500	

				төгрөгийн урсгал санхүүжилтын эрхийг нээлгэсэн. Урсгал санхүүжилтын 100900020001 тоот данснаас 7,666,337 мянган төгрөгийн, Нэмэлт санхүүжилтын 100900020414 тоот данснаас 7,295,900 мянган төгрөгийн зарлагын гүйлгээг тус тус боловсруулж хянан баталгаажуулсан. Тайлант хугацаанд 100900020001 тоот дансанд 39,8 мянган төгрөгийн, 100900020414 тоот дансанд 7,372,882 мянган төгрөгийн орлого орсон бөгөөд тус бүрийг бүртгэж баталгаажуулсан.	95
	Бараа материал, үндсэн хөрөнгийн орлого зарлагын гүйлгээнд хяналт тавин ажиллах	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Холбогдох хууль журам	Бараа материал, үндсэн хөрөнгийн бүртгэлийг хөтлөх, хяналт тавих	Бараа материал, үндсэн хөрөнгийн бүртгэл болон данс хөтлөлтийн бичилтэнд хяналт тавин, 1-12 дугаар сарын бараа материал, үндсэн хөрөнгийн орлого зарлагын гүйлгээнд хяналт тавин ажилласан. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасны дагуу Эрүүл мэндийн яамны үндсэн хөрөнгө болон эргэлтийн хөрөнгийн 2024 оны эхний хагас жилийн тооллогыг 06 дугаар сард зохион байгуулсан бөгөөд тооллогоор зөрчил дутагдал гараагүй болно. Одоо үндсэн хөрөнгө болон эргэлтийн хөрөнгийн 2024 оны жилийн эцсийн тооллогыг зохион байгууллахаар ажиллаж байна. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас жил бүр төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээг дүгнэдэг бөгөөд тус газарт холбогдох бичиг баримт, мэдээ, тайлан, тайлбарын хамт хүргүүлэн 2023 оны гэрээг 87% дүгнүүлсэн. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын улсын байцаагчийн албан шаардлагын биелэлтийг заасан хугацаанд нь гарган холбогдох газарт хүргүүлсэн. Мөн ТӨБЗГ-аас 2023 онд хэрэгжүүлсэн хяналт шалгалтын	87
7					

87

				мөрөөр авсан арга хэмжээ, илэрсэн зөрчил, дутагдлийг арилгасан байдалд гүйцэтгэлийн хяналт шалгалт хийсэн бөгөөд шалгалтын комисст холбогдох тайланг гарган өгч нотлох баримтын бүрдүүлбэрийг ханган гүйцэтгэлийн шалгалтын үнэлгээгээр 90% дүгнүүлсэн.	
8	Хуулийн хугацаанд бэлтгэгдэн гардаг тайлангуудыг хянаж баталгаажуулна	Нийгмийн даатгалын сар бүрийн тайлан, Хүн амын орлогын албан татварын улирал бүрийн хянаж баталгаажуулсан тайлан	Тооцооны нягтлан бодогчоос боловсруулж гаргасан тайлан, цалингийн бодолтыг шалган баталгаажуулж санхүүгийн программд бүртгэл хийж тайланг гаргасан байна.	ТАЦНС-ийн цалингийн системээс бодогдсон цалин, гэрээт ажиллагсадын цалинг баталгаажуулж сар бүрийн 10 болон 25-ны дотор цалинг олгосон. Нийгмийн даатгалын тайланг хуулийн хугацаанд сар бүр боловсруулж /Тооцооны нягтлан бодогч/, хянан баталгаажуулсан. Хүн амын орлогын албан татварын тайланг хуулийн хугацаанд улирал тутамд боловсруулж /Тооцооны нягтлан бодогч/ хянан баталгаажуулсан.	95
	Газар хэлтсийн даргаас өгсөн үүрэг даалгаврыг тухай бүрд биелүүлж ажиллах	Хууль, журмын хүрээнд хийж гүйцэтгэх	Өгсөн үүрэг даалгавар биелэгдсэн байх	Алдар цолтон, ахмад настанд төрөөс нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай хууль, УИХ-ын 2018 оны 03 дугаар тотоолын дагуу сар бүр ахмад настанд тэтгэмж олгож байгаа бөгөөд өргөдөл хүсэлтийг нь үндэслэн 2024 оны 01 дугаар сараас хойш 49 ахмадыг шинээр бүртгэн тэтгэмжийг олгосон. Мөн Алдар цолтон ахмад настны нэмэгдэл авч буй нийт ахмад настны мэдээллийг УБЕГ-т хүргүүлж, лавлагаа аван нас барсан 9 ахмад настныг бүртгэлээс хассан. УИХ-ын Хянан шалгах түр хорооноос зохион байгуулсан “Эмийн сонсгол”-той холбогдуулан 2020-2022 оны анхан шатны холбогдох баримтыг байгууллагын архиваас бүрдүүлэн, холбогдох тооцоо судалгааг гаргасан. Иргэн аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу Эрүүл мэндийн яамтай	
9				УИХ-ын Хянан шалгах түр хорооноос зохион байгуулсан “Эмийн сонсгол”-той холбогдуулан 2020-2022 оны анхан шатны холбогдох баримтыг байгууллагын архиваас бүрдүүлэн, холбогдох тооцоо судалгааг гаргасан. Иргэн аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу Эрүүл мэндийн яамтай	90

174

				холбоотой нэхэмжлэх үүсгэх болон нэхэмжлэх, төлбөрийн баримтын буцаалтыг татварын байгууллагын etax.mta.mn цахим хуудсанд үүсгэн ажилласан. Эрүүл мэндийн дэмжих санд АТГ-ын ажлын хэсгээс шалгалт орсонтой холбогдуулан өмнө онуудын санхүүгийн холбогдох материалуудыг байгууллагын дотоод архиваас хуулбарлан өгч, тайлбар мэдээллээр ханган ажилласан.	
ХОЁР. “НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ОЛОН УЛСЫН СТАНДАРТЫН ДАГУУ ТАЙЛАН БЭЛТГЭН ГАРГАХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД					
10	Байгууллагын улирал, хагас жил, жилийн эцсийн санхүүгийн тайланг бэлтгэн гаргах	НББОУС, УСНББОУС-ын дагуу хуулийн хугацаанд бэлтгэгдэн гарсан санхүүгийн тайлан	2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хуулийн хугацаанд, гаргаж баталгаажуулсан байна. Хагас жилийн санхүүгийн тайлангийн бэлтгэл хангаж ажилласан байна бэлтгэл ханган ажилласан байна.	Эрүүл мэндийн яамны 2023 оны санхүүгийн тайланг хуулийн хугацаанд гарган аудитын байгууллагад хүргүүлж, Аудитын дүгнэлтээр баталгаажсан тайланг Сангийн яамны mof.gov.mn цахим хуудсанд байршуулж Эрүүл мэндийн сайдын багцын нэгтгэл тайланд нэгтгүүлсэн. Мөн 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг хуулийн хугацаанд гарган Сангийн яамны mof.gov.mn цахим хуудсанд байршуулж Эрүүл мэндийн сайдын багцын нэгтгэл тайланд нэгтгүүлсэн	95
				Одоо 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг гаргахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	
11.	Эрүүл мэндийн яамны санхүүгийн тайланд аудит хийлгэж, дүгнэлт гаргуулах	Аудитын зөвлөмж, дүгнэлт	Аудитын гаргасан, зөвлөмж, акт, албан шаардлагын биелэлтийг гаргах төлөвлөгөө батлуулж хэрэгжүүлэн, аудитын программд бүртгэл мэдээлэл оруулах, хуулийн хугацаанд хариу хүргүүлэх	Эрүүл мэндийн яамны 2023 оны санхүүгийн тайланд хуулийн хугацаанд аудит хийлгэж, дүгнэлт гаргуулсан бөгөөд Энэ хугацаанд аудитаас шаардсан санхүүгийн холбогдох баримт материал, судалгааг гарган өгч нэмэлт тайлбар мэдээллээр ханган ажилласан болно. 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчилд дүгнэлт хийн албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг хангах	90

178

				төлөвлөгөөг гарган хуулийн хугацаанд аудитын байгууллагад хүргүүлсэн. Мөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг хуулийн хугацаанд гарган аудитын байгууллагад хүргүүлсэн бөгөөд аудитын <u>sso.audit.mn</u> цахим хуудсанд байршуулсан. Тус хугацаанд аудитаар илэрсэн 4,302,947 мянган төгрөгний зөрчил дутагдлыг арилгасан.	
12.	Төсөл хөтөлбөрийн санхүүгийн тайланг гарган сангийн яаманд баталгаажуулж тайлагнах	Төсөл хөтөлбөрийн санхүүгийн тайлан	2024 оны төсөл хөтөлбөрийн 3 тайланг өгсөн материалын дагуу бэлтгэн гаргасан байна.	2024 оны санхүүгийн тайлан гарахтай холбоотойгоор бэлтгэл ажлыг ханган төсөл хөтөлбөрөөр орж ирсэн мөнгөн дүнг нягталж холбогдох төсөл хөтөлбөртэй тооцоо нийлж ажилласан.	90
ГУРАВ. НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ					
13.	Удирдлагаас өгсөн бусад нэмэлт ажлыг хугацаанд нь гүйцэтгэх	Гүйцэтгэсэн ажлын тайлан	Хугацаанд нь гүйцэтгэсэн байна.	Эмийн сонсгол зохион байгуулахтай холбогдуулан холбогдох баримт материалыг бэлтгэн гаргаж өгсөн. Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын хүрээнд 12 Төрийн нарийн бичгийн даргын тушаалын төслийг боловсруулж, батлуулсан. 2024 оны 12 дугаар сарын 10-ны байдлаар Иргэн аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн 44 албан бичиг, 65 өргөдөл гомдлыг Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн дагуу хугацаанд нь шийдвэрлэж, хариу тайлбар мэдээллээр ханган ажилласан. Одоогоор шийдвэрлээгүй Иргэн аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн албан бичиг, өргөдөл гомдлын үлдэгдэлгүй байгаа болно..	90
14.	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, хэм хэмжээг мөрдөх	Ёс зүйн зөрчлийн тоо	Ёс зүйн зөрчилгүй ажилласан байна.	Төрийн албаны тухай хууль болон Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн дагуу Ёс зүйн зөрчил гаргалгүй, төрийн албан хаагчийн хэм хэмжээг мөрдөн ажилласан.	95
ДӨРӨВ. "ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД					

174

15.	ТАЦ-аас явуулж буй сургалтад хамрагдах	Сургалтад хамрагдсан байх	Тухай бүр сургалтад хамрагдсан байна.	Эрүүл мэндийн яамнаас нийт албан хаагчдад зориулан зохион байгуулж буй сургалт болон танилцуулгад тухай бүр хамрагдсан.	90
16.	Төсөв санхүү хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас санхүү, нягтлан бодох бүртгэл ээр явуулж буй сургалтад хамрагдах	Тухай бүр сургалтад хамрагдсан байна.	Сургалтад хамрагдсан байна.	Төсөв санхүү хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас санхүү, нягтлан бодох бүртгэлээр явуулж буй сургалтад тухай бүр хамрагдана.	90

ҮНЭЛГЭЭ ӨГСӨН:

САНХҮҮ, ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН ДАРГА:/Л.МӨНХЦЭЦЭГ/

2024.12.12

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:

АХЛАХ НЯГТЛАН БОДОГЧ:/Р.СОДНОМЦЭРЭН/